

**“ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН БА ХИЛИЙН
БАРУУН, ЗҮҮН БҮСИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БАГАЖ, ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙГ ШИНЭЧЛЭХ, СУУРИЛУУЛАХ, ХҮНИЙ НӨӨЦИЙГ
ЧАДАВХЖУУЛАХ ДАРААГИЙН ШАТНЫ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР МОНГОЛ
УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ,
ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ**

1. Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэг нь Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа хил хамгаалах, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээ, архив, оюуны өмч, улсын бүртгэл, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллага, мөн шүүх, прокурор, тагнуул, онцгой байдал, авлигатай тэмцэх, гааль зэрэг байгууллагуудын алба хаагчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, чөлөөнд байгаа ахмадуудад төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ, мөн Чингэлтэй дүүргийн иргэдэд гэмтэл, мэс засал, хүүхдийн тусламж, үйлчилгээ, нийт 250 гаруй мянган хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг нэгдсэн эмнэлэг юм.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд хилийн баруун, зүүн бүсэд ажиллаж, амьдарч буй алба хаагчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, ахмад хилчид, мөн хил орчмын оршин суугчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, алслагдсан бүс нутагт эрүүл мэндийн үйлчилгээг ойртуулах шаардлага тулгамдсан хэвээр байна.

Мөн эмнэлгийн үйл ажиллагааг өргөжүүлэх, оношилгоо, эмчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэхэд зайлшгүй шаардлагатай орчин үеийн дэвшилтэт технологи бүхий багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, тэдгээрийг суурилуулах, ашиглах орчныг бүрдүүлэх, шаардлагатай өрөө тасалгааг стандартын дагуу тохижуулах, эмч, сувилагч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулах шаардлага үүсээд байна.

Түүнчлэн хилийн хөдөлгөөнт анги, нэгтгэлүүдэд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд тогтмол хамруулснаар хорт хавдар, чихрийн шижин, бусад халдварт бус өвчнийг эрт үед нь илрүүлж, хүндрэлээс сэргийлэх, эмчилгээний үр дүнг сайжруулах бодит боломж бүрдэх юм.

Иймд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмнэлгийн хүчин чадлыг өргөтгөх, орчин үеийн тоног төхөөрөмж, технологийг нэвтрүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага үүсэж байна.

2. Салбарын болон эдийн засгийн үр ашиг

Төслийг хэрэгжүүлснээр эрүүл мэндийн салбарын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашиг нэмэгдэж, Монгол Улсын нийгэм, эдийн засагт дараах эерэг нөлөө үзүүлнэ:

Нэгдүгээрт, орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж нэвтэрснээр иргэд өндөр өртөгтэй, нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг дотооддоо авах боломж нэмэгдэнэ;

Хоёрдугаарт, катетр лаборатори, дурангийн болон бага зүслэгтэй мэс заслын тусламж хөгжсөнөөр өвчнийг эрт оношлох, эмчилгээний үр дүнг сайжруулах, хэвтэн эмчлүүлэх хугацааг богиносгох, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах боломж бүрдэнэ;

Гуравдугаарт, өдрийн стационарийн үйлчилгээ хөгжсөнөөр эмнэлэгт шаардлагагүй хэвтүүлэн эмчлэх тохиолдол буурч, орны эргэлт сайжирч, эмнэлгийн нөөцийг илүү үр ашигтай ашиглах нөхцөл бүрдэнэ;

Дөрөвдүгээрт, урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлгийн хөдөлгөөнт багийн үйл ажиллагаа өргөжсөнөөр хилийн болон алслагдсан бүсийн алба хаагчид, иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ ойртож, хорт хавдар, чихрийн шижин, зүрх судасны өвчин зэрэг халдварт бус өвчнийг эрт илрүүлэх боломж нэмэгдэнэ;

Тавдугаарт, төслийн хүрээнд хүний нөөцийг чадавхжуулснаар эмч, мэргэжилтнүүдийн ур чадвар нэмэгдэж, шинэ технологийг тогтвортой ашиглах, засвар үйлчилгээ, ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх нөхцөл бүрдэнэ.

Иймд төсөл нь зөвхөн эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл бус, эрүүл мэндийн салбарын чадавх, үйлчилгээний чанар, эдийн засгийн үр ашиг, бүсчилсэн хөгжлийг дэмжих нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой арга хэмжээ болно.

---o0o---